

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх дүүргийн Усан спорт сургалтын төвийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/042/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга	Ч.Болд
	Утас: 7000-7734	Цахим хаяг: boldch@audit.gov.mn
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга	Х.Түвшинбаяр
	Утас: 315558	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	С.Гантөгс
	Утас: 315558	Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
	“Тэд-Аудит” ХХК-ийн Ерөнхий захирал	Ц.Сугармаа
	Утас: 99151254	Цахим хаяг: ted.audit.llc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14

№

01/257

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянзүрх дүүргийн Усан спорт сургалтын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэл бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Баянзүрх дүүргийн Засаг даргатай 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан гэрээний 7.7-д "Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, гэрээг цуцлаагүй нөхцөлд дараа жилийн үйл ажиллагааны зорилтот түвшинг баталж гэрээнд хавсаргана" гэж заасан боловч сүүлийн 3 жилд тус төвийн зорилтот түвшний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй, даргын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж биелэлтийг хангаж ажиллаагүй байна.

Өмнөх онуудад нийт орлогыг 485,537.0 мянган төгрөг, нийт зардлыг 475,167.0 мянган төгрөгөөр баталсныг гүйцэтгэлээр орлогыг 86,443.3 мянган төгрөгөөр давуулж, зардлыг 103,005.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Бусад асуудал

Тус байгууллагын удирдлага нь тайлант жилд 3 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 90.0 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	30,884,994.29	6,118,081.01
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,708,481.10	2,477,257.48
1.1.6	Бараа материал	45,036,665.58	50,764,934.85
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	392,029.52	264,907.09
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	79,022,170.49	59,625,180.43
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,231,789,862.53	1,189,608,289.28
1.2.2	Биет бус хөрөнгө	1,873,105.91	994,318.15
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,233,662,968.44	1,190,602,607.43
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,312,685,138.93	1,250,227,787.86
2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.3	Татварын өр	3,206,396.97	2,681,605.06
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	654,634,157.40	599,096,674.44
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	203,076.75	-
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	658,043,631.12	601,778,279.50
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.20	Өр төлбөрийн нийт дүн	658,043,631.12	601,778,279.50
2.2	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	-	-
2.2.6	Дахин үнэлгээний нөөц	432,607,829.66	432,607,829.66
2.2.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	222,033,678.15	215,841,678.70
2.2.20	Эзэмшигчдийн өмчийн дүн	654,641,507.81	648,449,508.36
2.3	Үүнээс: Цөөнхийн хувь оролцоо	-	-
2.3.20	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	1,312,685,138.93	1,250,227,787.86

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого /цэвэр/	400,018,031.08	512,106,469.09
3	Нийт ашиг (алдагдал)	400,018,031.08	512,106,469.09
8	Бусад орлого	55,537,482.96	59,873,863.87
10	Ерөнхий ба удирдлагын зардал	433,938,035.45	571,117,609.19
12	Бусад зардал	9,171,105.82	7,054,723.22
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	12,446,372.77	(6,191,999.45)
19	Орлогын татварын зардал	62,231.86	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	12,384,140.91	(6,191,999.45)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	12,384,140.91	(6,191,999.45)
24	Орлогын нийт дүн	12,384,140.91	(6,191,999.45)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	448,917,599.20	582,584,401.21
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	399,987,592.51	512,330,471.76
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		409,090.91
1.1.6	Бусад мөнгөн орлого	48,930,006.69	69,844,838.54
1.2	Мөнгөн зарлагын дүн	452,639,003.29	606,760,859.95
1.2.1	Ажилчдад төлсөн	198,982,469.80	279,658,108.28
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	28,895,366.58	67,230,726.68
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	29,331,348.84	45,241,070.77
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	74,703,639.89	85,510,640.82
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,355,454.47	1,766,562.72
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	49,872,114.74	52,500,931.47
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	282,920.00	298,304.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	69,215,688.97	74,554,515.21
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,721,404.09)	(24,176,458.74)
2.2	Мөнгөн зарлагын дүн	3,195,090.91	590,454.54
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,195,090.91	590,454.54
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,195,090.91)	(590,454.54)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(6,916,495.00)	(24,766,913.28)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37,801,489.29	30,884,994.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,884,994.29	6,118,081.01

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Данскны код	Үзүүлэлт	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	432,607,829.66	209,649,537.24	642,257,366.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	432,607,829.66	209,649,537.24	642,257,366.90
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)		12,384,140.91	12,384,140.91
9	2023 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	432,607,829.66	222,033,678.15	654,641,507.81

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН УСАН СПОРТ СУРГАЛТЫН ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	432,607,829.66	222,033,678.15	654,641,507.81
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(6,191,999.45)	(6,191,999.45)
17	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	432,607,829.66	215,841,678.70	648,449,508.36

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 4,760.0 мянган төгрөгийн 4 алдаа илэрснээс аудитын явцад 4,532.2 мянган төгрөгийн 2 алдаа залруулагдаж, 227.8 мянган төгрөгийн 2 алдаа залруулагдаагүй.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа			Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Залруулсан	Залруулаагүй		Тоо	Дүн
								Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн элэгдэл буруу тооцсон	1				1				1			
Ажил олгогчийн НДШ-ийн зардлыг дутуу тооцсон	1	227.8			1	227.8			1	227.8		
Даатгалын нөхөн олговор болон бусад орлогод И баримт шивж баталгаажуулаагүй	1	627.5			1	627.5	1	627.5				
Татвар ногдох орлогоос хасагдах зардалд үйл ажиллагааны бус зардлыг /Хандив тусламжийн зардал/ оруулж татварыг тооцсон	1	3,904.7			1	3,904.7	1	3,904.7				
Дүн	4	4,760.0			4	4,760.0	2	4,532.2	2	227.8		

Аудитаар нийт 3 зөрчил илэрснээс, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Хөрөнгийг данснаас хасах шийдвэр гаргуулаагүй	1							1					
Байгууллагын дүрэм шинэчилж батлаагүй	1							1					

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН УСАН СПОРТ СУРГАЛТЫН ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зорилтот түвшин төлөвлөгөө шинэчилж батлаагүй	1				1							
Дүн	3				1		2					